

Эрүүгийн эрх зүй

**ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ,
ЭРХ ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

TRADITION OF FIGHTING FRAUD CRIME, LEGAL ANALYSIS



П.Эрдэнэбаатар

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн
процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш,
цагдаагийн хурандаа*

Хураангуй: Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөх шалгах арга зүйн асуудлыг авч үзэхийн өмнө тухайн гэмт хэргийн мөн чанар, эрүүгийн эрх зүйн, криминалистик шинжлэх ухааны тодорхойлолтыг нарийвчлан үзэх нь чухал бөгөөд залилах гэмт хэргийн криминалистик тодорхойлолтыг судлахын тулд Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэн хууль, тогтоомжуудын холбогдох зүйл, заалтыг судлан үзэх нь зүй ёсны хэрэг юм.

Abstract: Before considering methodological issues of specific crime investigation, to see in detail of definition of crime, criminal law, the description of criminalistics science is critical and in order to study fraud crime's the description of criminalistics, Mongolia's historical criminal law, norms, related matter, provisions is must.

Түлхүүр үгс: Залилах, Иргэний эрх зүйн гэрээний харилцаа, хуурах, зохиомол, нөхцөл байдал, сүсэг бишрэл, бодит байдлыг нуух, төөрөгдөлд оруулах, урьдын харилцааны явцад бий болсон итгэл, албан тушаалын байдал, ноцтой хохирол, амьдралын эх үүсвэр болгох

Key words: Fraud, contractual relationship of civil rights, cheat (trick), fictitious conditions, devotion, hide reality, to confuse, trust that built from previous relationships, position, major damage, to make source of life.

УДИРТГАЛ

Монгол Улсад 1921 онд Ардын хувьсгал ялж, ардын шинэ төр засаг тогтоон бэхжүүлэхийн зэрэгцээ ард ангийн эрх ашгийг илэрхийлсэн хувьсгалт хууль ёс, дэг журмыг хэвшүүлэн тогтоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрүүгийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж ирсэн түүхэн эх сурвалжаас харагддаг. Монгол Улсын анхдугаар их хурал 1924.11.8-нд нээгдэж улс орны тулгамдсан олон асуудал шийдвэрлэсний нэг нь анхны Үндсэн хуулийг 1924.11.26-нд баталж БНМАУ-гэж улсаа тунхаглан зарласнаар Монгол улсын эрх зүйн цоо шинэ тогтолцоонд шилжих түүхэн үе эхэлсэн байна¹.

1926.1.15-нд Монгол Улсын анхны Эрүүгийн хууль, буюу Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг, мөн оны 11 дүгээр сарын 11-нд тусгай ангийг батлан гаргажээ. БНМАУ-ын 1926 оны шүүх цаазын бичигт Монгол Улсын нийгэм дэх эрүүгийн эрх зүйн харилцааг бие даасан салбар хууль буюу Эрүүгийн хуулиар зохицуулалтыг зааж өгчээ. Шүүх цаазын бичгийн 1 дүгээр зүйлийн тайлбарт гэмт хэргийн ойлголтыг "Аливаа цааз хууль дор заасан эл явдлыг гэмт хэрэг дор тооцвоос зохино"² гэж анх удаа хуульчилж өгсөн юм. Уг хуулийн 30 дугаар бүлэгт хулгайлах, булаах ба дээрэмдэх зэргээр бусдын эд хөрөнгийг сүйтгэх нь хэмээн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг хуульчилсны дотор Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа залилан мэхлэх гэмт хэргийг хулгайлах, булаах, дээрэмдэх зэрэг гэмт хэргүүдээс тусад нь бие даасан байдлаар бүрэлдэхүүнийг тогтоон, оногдуулах ял шийтгэлийг тодорхойлж өгсөн байна.

Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 214 дүгээр зүйлд залилан мэхлэх гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан.Тухайлбал,

214 дүгээр зүйл: Ашгийг хичээж мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан шингээвээс 6 сараас 5 жил хүртэл гянданд хорино.

215 дугаар зүйл: Дээрх зүйлд дурдсан гэмт явдлын улмаас улсын ба ард олноор байгуулсан газруудын хөрөнгөнд сүйтгэл гаргаваас 1-7 жил хүртэл гяндан хорихоос гадна хөрөнгийг нь бүрэн буюу заримыг нь албанд хурааж болно.

¹ БНМАУ-ын түүх. Уб., 1969. III боть. 215 дахь тал.

² И. Дашням, Д. Далайбаяр, нарын эмхэтгэсэн БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл (1926). Уб., 2002. 6 дахь тал.

216 дугаар зүйл: Энэхүү цааз бичгийн 214 дүгээр зүйлд дурдсан гэмт явдлыг үйлдэхэд айлган доромжлох зэрэг арга хэрэглэвээс 1-6 жил хүртэл гяндан хорино"¹.

Дээрх заалтуудаас үзэхэд тухайн үед залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг а/ашгийг хичээж; б/залилан мэхэлж; в/бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг; г/ашиглан шингээх гэсэн байдлаар тогтоож өгсөн байна.

1929 оны Шүүх цаазын бичигт. Шүүх цаазын бичгийн Тусгай ангийн 29 дүгээр бүлэгт Хулгайлах булаах ба дээрэмдэх зэргээр бусдын эд хөрөнгийг сүйтгэх нь хэмээн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг системчилсний 216, 217, 218 дугаар зүйлүүдэд залилан мэхлэх гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан байна.

216 дугаар зүйл. Ашгийг хичээж залилан мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан шингээвээс 5 жил хүртэл хормой.

217 дугаар зүйл. Дээрх зүйлүүд дор дурдсан явдлын улмаас ард олноор байгуулсан газрын хөрөнгөн дор сүйтгэл гарваас 1-7 жил хүртэл хорихоос гадна хөрөнгийг бүрэн буюу заримыг албан хурааж болмуй.

218 дугаар зүйл. Энэхүү цаазын бичгийн 216 дугаар зүйл дор дурдсан гэмт явдлыг үйлдэхүй дор дарлан доромжлох зэрэг арга хэрэглэвээс 1-6 жил хүртэл хормой"².

1934 оны Шүүх цаазын бичигт: "Эд хөрөнгийн гэмт хэргүүд" хэмээх 7 дугаар бүлгийн 143 дугаар зүйлд залилан мэхлэх гэмт хэргийг "...Бусдын мөнгө буюу эд хөрөнгийг ба эзэмшиж эдлэх эрхийг залилан мэхлэх аргаар шилжүүлэн авсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино" гэж заажээ.

Тийнхүү бусдын эд хөрөнгийг эзэмшиж эдлэх эрхийг залилан мэхлэх аргаар шилжүүлэн авах явдал үйлдсэнээс улсын ба олон нийтийн газруудад үлэмжхэн хохирол учруулсан бол 1-5 жил хүртэлх хугацаагаар хорих, хөрөнгийг бүрэн буюу заримыг нь хураах ял шийтгэвэл зохино. . ."3 гэж нэг заалтад /143 дугаар зүйлд/ уг гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх шинжийг цуг хуульчилсан боловч, ялыг өөр өөрөөр тогтоосноор

¹ И.Дашням,Д. Далайбаяр, нарын эмхэтгэсэн БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл (1926). Уб., 2002. 14 дэх тал.

² Монгол Улсын Үндэсний төв архив. Ф-284. Т-1. х/н-610. 81 дэх тал.

³ БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. Уб., 1934. 34 дэх тал.

бүрэлдэхүүнүүдийг ялгах боломж бүрдүүлжээ. ..."Хэн хүн алив хутагт хувилгаан хэмээх нэрийг хэрэглэх буюу олгох зэргээр олныг мэхлэх..." /116 дугаар зүйл/, "...хүмүүсээс тусгай зүйлд итгэмжлүүлэхээр өгсөн...эд хөрөнгийг ашгийг хичээж, хувьд ашиглан шийтгэх, шамшигдуулах..." /142 дугаар зүйл/, "Цэргийн гавьяаны одон тэмдэг болон үйлдвэрийн гавьяаны одон тэмдгийг зүүх эрхгүй этгээд нараас зүүсэн..." /149 дүгээр зүйл/ зэрэг гэмт үйлдлүүдийг залилан мэхлэх гэмт хэргээс тусдаа бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан нь зүйлчлэлийн асуудал зохих түвшинд хүрсэн хүрсэн байна.

Залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд а/хорих, б/эд хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах ялыг шийтгэхээр заасан. Өөрөөр хэлбэл, хүндрүүлэх байдалтайгаар буюу залилан мэхлэх гэмт хэргийн улмаас улс, олон нийтийн газруудад үлэмжхэн хохирол учруулбал эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэхээр хуульчилжээ.

БНМАУ-ын 25 дугаар Бага хурлаас 1942.1.17-ны өдөр гаргасан тогтоолоор "БНМАУ-ын Эрүүгийн хууль"-ийг баталсан нь шинэ Үндсэн хуулийн агуулгад бусад хууль тогтоомжуудыг нийцүүлэх ажлын хүрээнд урьд хэрэглэж байсан Шүүх цаазын бичгийн (1934 оны) хүчин чадлыг дуусгавар болгож, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа "Эрүүгийн хууль" нэртэйгээр кирилл үсгээр хэвлэгдэж,¹хүчин төгөлдөр мөрдөгдөх үндэс болжээ.Тус хуулийн "Эд хөрөнгөний гэмт хэргүүд" хэмээх 8 дугаар бүлгийн 178 дугаар зүйлд "Итгэснийг тэсрүүлэн бусдын мөнгө хөрөнгө буюу эрхийг авахын тулд санаатайгаар залилан мэхлэх аргыг хэрэглэвэл 3 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ. Бусдын эд хөрөнгө ба мөнгийг эзэмшин эдлэх эрхийг залилан мэхлэх аргаар авсныг улсын ба олон нийтийн газруудад алдагдал хохирлыг учруулсан байвал нэгэн жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорьж, хөрөнгийг бүрэн буюу заримыг хураавал зохино" гэж зааснаар залилан мэхлэх гэмт хэрэг нь өөрөө бие даасан гэмт хэргийн шинжтэй болохыг анхлан тодорхойлжээ. Энэхүү хуулиар залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгсдэд хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар ял шийтгэж байжээ². Мөн Эрүүгийн хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар ашигт шунасан (Залилан мэхлэх) гэмт хэргийг үйлдэж

¹ Соёл гэгээрлийн байгууллагуудын ажлын талаар холбогдолтой зарлиг, тогтоол заавруудын системчилсэн эмхэтгэл. УБ.,1962. 6 дахь тал, ШУА-ийн мэдээ. УБ.1963. №3.66 дахь тал, МАХН-ын тогтоол шийдвэр баримт бичгүүд. Уб.,1985.боть 346 дахь тал.

² БНМАУ-ын Эрүүгийн хууль. -УБ.,1947

хорих ялаар шийтгүүлэх тохиолдолд уг ялтны тэтгэвэр авах эрхийг хасах үндэслэл болдог байв.

БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуулийн¹, тусгай ангийн “Иргэдийн амины өмчийн эсрэг гэмт хэрэг” хэмээх V бүлгийн 110 дугаар зүйлд Залилан мэхлэх гэмт хэргийг тодорхойлохдоо: а) Залилан мэхэлж итгэлийг эвдэх, замаар иргэдийн амины хөрөнгө буюу түүнийг эзэмших эрхийг авч ашиглавал 3 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ. б) Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай буюу бүлэглэж буюу давтан үйлдсэн, эсхүл хохирогч этгээдэд их хэмжээний хохирол учруулсан бол хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах эсхүл хураахгүйгээр 7 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ”,

114 дүгээр зүйл: Улс олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулсан, дээрэмдсэн, хулгайлсан, булаасан хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд залилан мэхлэх буюу шунахай зорилгоор далайлган сүрдүүлэх гэмт хэрэг үйлдвэл хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах буюу хураахгүйгээр 2-8 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ гэж тус тус заажээ.

1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн² 127 дугаар зүйлд Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг залилан мэхэлж ашиглан шамшигдуулах гэмт хэргийг тодорхойлохдоо:

1. Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар авсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл дөрвөн зуугаас хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жилээс нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад их хэмжээтэй хохирол учирсан буюу уг үйлдлийг онц аюултай рецитив гэмт хэрэгтэн хийсэн бол эд

¹ БНМАУ-ын хуулиуд. I. Уб., 1980. 63 дахь тал.

² БНМАУ-ын Эрүүгийн хууль. Уб., 1987.

хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ.

Тус хуулийн 5 дугаар бүлэгт Иргэдийн амины өмчийн эсрэг гэмт хэргийг системчилж, 157 дугаар зүйлд дараах байдлаар залилан мэхлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчилсан.

1. Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар иргэдийн амины эд хөрөнгийг авсан буюу түүнийг эзэмших эрхийг олж авсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас хохирогчид үлэмж хэмжээтэй хохирол учирсан уг үйлдлийг онц аюултай рецитив гэмт хэрэгтэн хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

Эрүүгийн хуулийн 127 дугаар зүйлд заасан социалист өмчийг залилан мэхлэх гэмт хэргийг 157 дугаар зүйлд заасан залилан мэхлэх гэмт хэрэгтэй харьцуулахад гэмт хэргийн бүрэлдэхүүн зөвхөн объектоороо л ялгагдан зүйлчлэгдэх бөгөөд, залилан мэхлэх гэмт хэргийн халдлагад социалист өмч өртвөл 127 дугаар зүйлээр зүйлчилж, ялын бодлого нь бүх заалтаар 157 дугаар зүйлээс хүндэрч заагдсан онцлог харагддаг.

Монгол улсад 1990-ээд оноос нийгэм, эдийн засгийг бүхэлд нь хамарсан шинэчлэлт, өөрчлөлтийн уур амьсгал эрчимжиж, 1990 оны 9-р сард БНМАУ-ын АИХ-ын чуулганаар Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль батлан гаргасны 2 дугаар бүлэгт улсын эдийн засгийн үндсийг социалист аж ахуйн систем, үйлдвэрлэлийн хэрэгслийг нийтээр өмчлөх социалист өмч гэж тодорхойлж байсныг хүчингүй болгож олон хэвшилт өмчтэй эдийн засгийг хүлээн зөвшөөрсөн билээ. Энэ заалт хожим 1992 оны шинэ Үндсэн хуульд тусгалаа олсон билээ. Үндсэн хуульд орсон энэхүү нэмэлт өөрчлөлтийн дагуу 1990 оны 12 дугаар сарын 28-нд “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдаж, хувийн болон нийтийн өмчийг гэмт халдлагаас адил тэгш хамгаалах явдлыг Эрүүгийн хуулийн нэг чухал зорилт болгожээ. 1986 оны Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 3, 5 дугаар бүлгийн зүйлүүдийг нэгтгэж 3 дугаар бүлгийг өөрчлөн найруулсан билээ. 1961 оны Эрүүгийн хуулиас хойш улс, хоршоолол, олон нийтийн эд

хөрөнгө, иргэдийн амины эд хөрөнгө гэж Эрүүгийн хуулиар тусад нь ялгаатай хамгаалж байсан бол бусдын эд хөрөнгийг "Залилан мэхэлж ашиглан шамшигдуулах" гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 127 дугаар зүйлд хуульчилж, 157 дугаар зүйлийг хүчингүй болгожээ. Монгол Улсын Их хурлаас 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдөр “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль” -ийг баталсан байна. Уг Эрүүгийн хуулийн тусгай ангийн "Өмчийн эсрэг гэмт хэрэг"-ийн 3 дугаар бүлгийн 127 дугаар зүйлд "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж ашиглан шамшигдуулах" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар хуульчилсан байна.

1 дүгээр хэсэг: Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар бусдын эд хөрөнгийг авсан буюу түүнийг эзэмших эрхийг олж авсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 25000-200000, хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2 дугаар хэсэг: Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жилээс 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 50000-500000 төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3 дугаар хэсэг: Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас бусдад их хэмжээтэй хохирол учирсан буюу уг үйлдлийг онц аюултай гэмт хэрэгтэн хийсэн бол 5-15 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1993 оны Эрүүгийн хуулийг практикт хэрэглэх явцад нэг мөр ойлголт өгөх үүднээс "Өмчийн эсрэг гэмт хэрэг"-ийг тайлбарласан УДШ-ийн бүгд хурлын тогтоолууд 1991, 1997 онуудад гарч байсны дотор залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг хэрхэн ойлгох талаар өгсөн албан ёсны тайлбарууд өнөөдөр ч эрүүгийн эрх зүйн онол практикт үнэ цэнээ алдаагүй байна.

1999.07.21-ний өдөр Монгол Улсын Их хурлаас 127.1 дүгээр зүйлд "Банкнаас авсан зээлийг төлөхөөс санаатайгаар зайлсхийж их хэмжээний хохирол учруулах" хэмээх гэмт хэргийг залилан мэхлэх гэмт хэрэгтэй төсөөтэй гэж үзэн шинээр хуульчилж, харьцангуй, хүнд ял оноохоор зааснаас гадна, тэр үед Эрүүгийн хуульд байхгүй зохицуулалт болох "учирсан хохирлыг нөхөн төлүүлж" гэсэн санкцыг суулгасан нь амьдралд төдийлөн тохиромжтой бус зөв шийдэл болж чадаагүй гэж судлаач үздэг. Энэ хуулиар залилан мэхлэх гэмт хэрэгт тэр дундаа улс, олон нийтийн эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэгт ял оногдуулахдаа харьцангуй хүндрүүлж тусгайлан авч үздэг байсан өмнөх хуулийн агуулга байхгүй

болсон нь нэг талдаа, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн ялын бодлого суларч, уг гэмт хэргийн гаралт нэмэгдэх нэг төрлийн нөхцөл болсон гэж үздэг.

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг гэсэн ойлголтыг анх удаа 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын Их хурлаас баталсан Эрүүгийн шинэ хуулийн тусгай ангийн 7 дугаар хэсэгт бие даасан байдлаар хуульчилсан нь Эрүүгийн хуулийн системчлэлд чухал хувь нэмэр оруулсан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлд "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах" гэмт хэргийг тодорхойлсон эрүүгийн эрх зүйн гурван хэм хэмжээг шинээр хуульчлан тогтоосон байдаг.

148.1-д:Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэлх хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

148.2-т: Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалтан байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.3-т:Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ .

Хууль тогтоогч дээрх зүйлийн I хэсэгт /148.1/ уг гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжийг, II хэсэгт /148.2/ энэ гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг, III хэсэгт /148.3/ дээрх 1,11 хэсгүүдэд заагдсан

гэмт хэргийг онц хүндрүүлэх шинжийг зааж өгсөн байна. Энэ байдлаас үзэхэд бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг нь:

- үндсэн бүрэлдэхүүн
- хүндрүүлэх бүрэлдэхүүн
- онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэж үзэж болно.

Энэ хуулиар залилан мэхлэх гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжид уг гэмт хэргийг өмчийн эсрэг бусад гэмт хэргээс ялгагдах, залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэх хамгийн анхдагч ерөнхий об'ектив, субъектив шинжийг тодорхойлж өгсөн байдаг. Ингэснээрээ уг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авахад ялыг хүндрүүлж үзэх, үндсэн бүрэлдэхүүнээс нийгмийн хор аюулын хэр хэмжээгээр үлэмж их нөхцөл байдлуудыг хуульчилсан юм. Тухайн гэмт хэргийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авахдаа онц хүндрүүлж үзэх буюу үндсэн, хүндрүүлэх бүрэлдэхүүнээс нийгмийн хор аюулаар онц их нөхцөл байдлыг тодорхойлж өгсөн байна. Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг ялгавартайгаар тогтоосны гол учир холбогдол нь тухайн гэмт хэрэгт эрүүгийн эрх зүйн үүднээс үнэн зөв үнэлэлт дүгнэлт өгөх, амьдрал бодит байдалд янз бүрийн байдлаар үйлдэгдсэн тохиолдолд нийгмийн хор аюулыг оновчтой тодорхойлох тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн тус бүр эрх зүйн өөр өөр үнэлэмжийг төрүүлж байдагт оршино.

Монгол Улсад 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дэх хэсгийн 3.2-т "олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын арга" ашиглан бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эзэмших, өмчлөх эрхийг авах үйлдлийг залилах гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан ч мөрдөгч, прокурор, шүүгчдийн хувьд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийдвэрлэх шинэлэг байдалтай байгаа билээ.

Залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл, Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй¹. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн

¹ Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992

өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө", "Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй"¹ гэж заасан нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объект болно.

Халдлагын зүйл нь бусдад залилагдсан эд хөрөнгө байна. Бусдын эд хөрөнгө гэж Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд тодорхойлсон өөр этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа эд юмсыг ойлгоно. Энэ гэмт хэргийн объектив тал нь бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан идэвхтэй үйлдэл байна. Залилах гэмт хэргийг хохирлын хэмжээ шаардахгүй, хэлбэрийн шинжтэйгээр хуульчилсан. Өөрөөр хэлбэл, хуульд заасан аргаар бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авснаар гэмт хэрэг төгсдөг байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт залилах гэмт хэрэг гүйлдэх аргыг заасан учраас объектив талын үндсэн шинжийг илэрхийлж, гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлнө. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд энэ гэмт хэргийг хуурах, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах аргаар үйлдсэн байна.

Гэмт хэргийн объектив талын шинж болох үйлдлийн аргыг диспозицид дэлгэрэнгүй заасан нь өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэрэг, иргэний эрх зүйн зөрчлөөс ялгагдаж байна.

Бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан гэж хуульд заасан арга хэрэглэж, хохирогчийг төөрөгдүүлсний үндсэн дээр түүний зөвшөөрлийн дагуу хариу төлбөргүйгээр, бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн өмчлөлд хууль бусаар авах үйлдлийг хэлнэ.

Хуурах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд үгээр, үйлдлээр эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх, өмнөх харилцаанд тулгуурлан итгэл эвдэхийг ойлгоно.

¹ Иргэний хууль. УБ., 2002

Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хуурамч бичиг баримт, эд зүйл, цахим хэрэгсэл, цахим сүлжээ, цахим мэдээлэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, техник хэрэгсэл ашиглах, тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргийг ойлгодог.

Дээр дурдсан тайлбараас... Цахим хэрэгсэл, цахим сүлжээ, цахим мэдээлэл, техник хэрэгсэл ашиглах гэсэн заалт нь бидний авч үзэж байгаа цахим орчинд залилах гэмт хэрэгт шууд хамааралтай учир тэдгээрийн талаар болон мөн тэдгээрт шууд хамааралтай бусад ойлголтууд тус бүрд нь нарийвчилсан тодорхойлолт өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Үүнд: компьютер гэж өөрийнх нь үйлдлийг зохицуулах үүрэгтэй программаар тодорхойлогдсон удирдлагын дор мэдээллийг боловсруулах автоматчилагдсан үйлдэл гүйцэтгэгч төхөөрөмжийг хэлнэ.¹

Компьютерын дагалдах төхөөрөмжүүд гэж хамтарсан байдлаар өгөгдлүүдтэй хавсран ажиллах төрөл бүрийн үүрэг, зориулалт бүхий бүрдэл хэсгүүд- (хувилагч болон дамжуулагч төхөөрөмжүүд, мэдээлэл тээгч бие даасан хэрэгсэл, төхөөрөмжүүд) гэх зэргийг ойлгоно.²

Компьютерын сүлжээ гэдэгт компьютеруудын өөр хоорондын холбоос эсвэл тооцоолох төхөөрөмж (жишээ нь серверүүд), компьютер хоорондын холбоосыг ойлгоно. Компьютерын программ буюу программ хангамж гэдэг бол тооцоолох төхөөрөмжид зориулагдсан үйлдлийн дэс дарааллын зааварчилгаа мөн.³

Өгөгдлийн урсгал гэж дээр нэр дурдсан сүлжээ, эсвэл дагалдах төхөөрөмжүүдээр шилжин байршиж байгаа, боловсруулагдаж байгаа мэдээллүүдийг нэрлэнэ.

Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нэгэн төрөл болохынх нь хувьд залилан мэхлэх гэмт хэргийн тухайд хэрэглэгч гэдэгт нэг талаас

¹ Оросын Их нэвтэрхий толь бичиг. 30 дугаар боть. .Ред. Кравец С.Л. -М. 2009. С.52-59.

² НҮБ-ын “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрхзүйн зарчил гаргагчидтай хэрхэн харьцах тухай” 10 дугаар Чуулганы материалууд. 5 дугаар зүйл. Вена. 2000 оны 04 сарын 10-17. А\CONF 187\10

³ Тушканова,О.В. Терминологический справочник судебной компьютерной экспертизы. Справоч.пособие. М. 2005. С.109.

хохирогч тал гэмт санаа зорилгоор ашиглагдаж байгаа компьютер өгөгдөл эсвэл мэдээллийн бүрэлдэхүүн, нөгөө талаас мөнхүү гэмт хэргийг үйлдэж буй этгээдийг тус тус ойлгоно.

Зохиомол байдлыг зориудаар бий болгох гэж эд хөрөнгийн эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх, хууран мэхлэхийн тулд зохиомол байдлыг зориуд бий болгохыг ойлгоно.

Сүсэг бишрэлийг далимдуулах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хохирогчийн сүсэг бишрэл, шашны итгэл үнэмшлийг ашиглан төөрөгдүүлэхийг ойлгоно.

Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах гэж дампуурсан ажиллагаа нь зогссон, доголдсон, санхүүгийн алдалтай, хөрөнгө оруулалт шаардлагатай байдлыг нуух, хуурамч аудитын дүгнэлт гаргуулах зэргээр бусдыг төөрөгдүүлж, эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн авахыг ойлгоно.

Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж гэдгийг шууд ойлгож, хэрэглэнэ.

Залилах гэмт хэргийн субъектив шинж нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй, эсхүл хагасыг нь хийнэ гэсэн субъектив санаа зорилго гэмт этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө бий болсон байдгаараа залилах гэмт хэрэг нь гэрээний эрх зүйн маргаанаас ялгагдана.

Залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинж: Албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн гэж хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээний үндсэн дээр олгогдсон албаны бүрэн эрх, албан тушаалын байдлаа бусдыг залилж, түүний эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль бусаар шилжүүлэн авах гэмт үйлдэлдээ давуу тал болгон ашигласан байхыг ойлгоно¹.

Бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсан, эсхүл тавин мянган нэгжтэй

¹ Эрүүгийн хууль. Уб., 2015, 7 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг

тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсныг ойлгоно.

Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэж залилах гэмт хэргийг гурав ба түүнээс дээш удаа үйлдэж олсон хууль бус орлогоороо өөрийгөө болон гэр бүл, бусдыг тэжээн тэтгэж байгаа явдлыг ойлгоно.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхийг хориглосон аж ахуйн үйл ажиллагаа явуулах замаар үйлдсэнийг ойлгоно. Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйвар гэж бусдыг элсүүлэх эрх олж авахын тулд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардан, бусдыг элсүүлсний төлөө мөнгө өгөх бизнесийн хууль бус үйл ажиллагааг хэлнэ. Энэхүү хууль бус үйл ажиллагаа нь нэгдүгээрт бараа, бүтээгдэхүүн дээр суурилж, бараа эргэлтэд анхаардаг олон шатлалт маркетингийн арга бөгөөд хүн элсүүлж, сүлжээ үүсгэн, бараагаа олон хэрэглэгчид хүргэх зорилготой байдаг бол хоёрдугаарт, гарт баригдах бодит эргэлтгүй боловч их мөнгө амлаж, хүн элсүүлдэг пирамид тогтолцооны луйвар тус тус хамаарна. Хүндрүүлэх шинжид энэ үйлдлийн аргыг хуульчилсан нь практикт түгээмэл үйлдэгдэж, иргэдэд их хэмжээний хохирол учруулдаг "Сүлжээний луйвар"-тай тэмцэхэд ач холбогдолтой.

Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэж гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдэл үйлдсэнийг ойлгоно.Тайлбар, зүйлчлэл:

- Залилах гэмт хэрэг бусад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, тухайлбал, хулгайлах, дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх, авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах гэмт хэргээс өмчлөгч хууртагдан итгэсэн учраас гэмт этгээдэд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээ сайн дураараа өгсөн байдгаараа ялгаатай.

- Залилах гэмт хэргийн тухайд гэмт этгээд анхнаасаа бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн аваад буцаан өгөхгүй, өмчлөх эрхийг сэргээхгүй байх санаа зорилготой байх бөгөөд ингэхийн тулд өмчлөгчийг хууран мэхэлж, төөрөгдүүлсний улмаас эд хөрөнгө, эд хөрөнгийг эрхийг шилжүүлэн авсан байна.

- Гэрээний харилцаа нь Иргэний хууль тогтоомжийн дагуу үүсэж, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, гэрээгээ дүгнэж байсны эцэст эрсдэлд орсны улмаас

үүссэн маргааныг, өөрөөр хэлбэл, гэрээний эрсдэлийг залилах гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж, бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн бол залилах гэмт хэргээр зүйлчилнэ.

- Байгалийн давагдашгүй хүч, нийгэм, эдийн засгийн харилцааны зохицуулалтын өөрчлөлт, гэнэтийн осол, өвчин эмгэг, хорио цээр зэрэг талуудаас үл шалтгаалах хүчин зүйл буюу нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжгүйгээр гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүйг залилах гэмт хэрэг гэж үзэхгүй.

- Залилах гэмт хэргийн халхавч болсон гэрээ хэлцэл нь хуурч мэхлэх, итгэл эвдэх арга дээр үндэслэгдсэн, шунахай сэдэлтээр, дан ганцаар ашиг олох, гэрээнд оролцогч нөгөө талаа хохироох зорилгоор хийгдсэн байдаг бол иргэний эрх зүйн гэрээний харилцаа нь талуудын чөлөөт байдал, тэгш эрх, харилцан тодорхой үр дүнд хүрэхийн тулд хийгддэг учир гэрээ анхнаасаа биелэгдэх бодит боломжгүй байсан нь тогтоогдсон, үүнийгээ гэрээний нэг тал урьдчилан мэдсээр байж байгуулсан, нөгөө тал хохирогч нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бол залилах гэмт хэрэг гэж үзнэ.

Бусдыг эд хөрөнгийг зээл нэрээр халхавчлан залилах нь уг зээлийг буцаах төлөх бодит баталгаагүй, тухайлбал, барьцааны хөрөнгөгүй, хөрөнгө нь байлаа ч гэсэн эрхийн зөрчилтэй, тухайн эд хөрөнгийг барьцаалах бүрэн эрхгүй этгээд барьцаалсан, түүнчлэн, Иргэний хуульд заасан барьцааны гэрээ байгуулах журмыг санаатай зөрчсөн байдаг зэргээр иргэний эрх зүйн зээлийн гэрээнээс ялгагдана.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Залилах гэмт хэрэг болон иргэний эрх зүйн маргааны ялгаатай болон төсөөтэй талуудыг авч үзвэл. Үүнд:

Ялгаатай төсөөтэй шинж	Залилах гэмт хэрэг	Гэрээний харилцаанаас үүссэн маргаан (зөрчил)	Тайлбар
Объект	Бусдын өмчлөх эрх	Эд хөрөнгийн сонирхол	---
Халдлагын	Эд хөрөнгө, мөнгө	Мөнгө, эд	---

зүйл		хөрөнгийн эрх, анз, олох байсан орлого	
Объектив тал	Хуурах, төөрөгдүүлэх, Итгэл эвдэх аргаар бусдын өмчлөлийн эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар шилжүүлэн авсан үйлдэл	Гэрээгээр хүлээсэн үүргээ зохиох ёсоор биелүүлэхгүй үйлдэл, эс үйлдэхүй	---
Субъект	16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай хувь хүн	Хувь хүн, хуулийн этгээд байх болно.	---
Хохирол	Ердийн бүрэлдэхүүн-ний хувьд хохирол шаардахгүй	Мөнгө, эд хөрөнгийн эрх, анз, олох байсан орлого	Шууд бус Хохирол тооцдог эсэхээрээ ялгаатай.
Субъектив тал	Хариу төлбөргүйгээр, өөрийн өмчлөлд авч буйгаа мэдэж, түүнийг хүсэж үйлдсэн гэм буруугийн шууд.санаатай хэлбэртэй,шунахай сэдэлтэй.	Ашиглан шамшигдуулах шинжгүй	Субъектив санаа зорилго гэмт этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлэхээсээ өмнө бий болсон. (Дурдсанаас бусад тохиолдол)
Хариуцлага харилцааны онцлог	Төр давуу эрхтэй буюу гэмт этгээдэд хүлээлгэж оролцоно.	Оролцогч талууд тэгш эрхтэй оролцоно.	---

Эрдэмтэн, судлаачдын бүтээлд шашинтай холбоотойгоор хүнийг хуурч залилсан болон сүсэг бишрэлийг далимдуулах гэж тайлбарладаг. Уг үйлдлийг аргаар үйлдсэн хэрэг одоогоор бүртгэгдээгүй байна.

Дампуурсан, үйл ажиллагаа нь зогссон, доголдсон, санхүүгийн алдагдалтай, хөрөнгө оруулалттай шаардлагатай байдлыг нуух, хуурамч аудитын дүгнэлт гаргуулах зэргээр бусдыг төөрөгдүүлж, эд хөрөнгийн өмчлөх эрхийг шинжлүүлэн авч бусдыг төөрөгдөлд оруулсан 131 хэрэгт шийдвэрлэсэн хэргийн судалгаа.

Залилах гэмт хэргийг ах, дүү, эцэг, эх, хамаатан садан, танилын хүрээгээ ашигласан үлдэлтэй 87 хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна¹.

№	Үйлдлийн арга	Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь
---	---------------	----------------------------	------------

¹ Я. Батханд Залилах гэм хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, боловсронгуй болгох арга зам. хууль зүйн докторын диссертаци. УБ., 2022. 95 дахь тал

1	Хуурч	349	41 хувь
2	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	117	14 хувь
3	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	161	18 хувь
4	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0 хувь
5	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	138	17 хувь
6	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	87	10 хувь

Эрүүгийн хуулийн тусгай 17.3 дахь хэсгээр шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн 293 магадлалд дүн шинжилгээ:

№	Үйлдлийн арга	Шинжилсэн хэрэг	Эзлэх хувь
1	Хуурч	127	43 хувь
2	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	48	16 хувь
3	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	57	19 хувь
4	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0 хувь
5	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	39	13 хувь
6	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	22	8 хувь

Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн УДШ-ийн 185 дугаар тогтоолд дүн шинжилгээ хийхэд:

№	Үйлдлийн арга	Шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь
1	Хуурч	111	60 хувь
2	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	18	9 хувь
3	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	21	11 хувь
4	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0 хувь
5	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	24	13 хувь
6	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	11	6 хувь

Залилах гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн практик болон шийдвэрлэлтийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор

хууль сахиулах байгууллагын алба хаагчдаас анкетын аргаар судалгаа авахад:

Судалгаанд хууль сахиулах байгууллагын 200 ажилтан, албан хаагчид хамрагдсан бөгөөд тэдний 28 хувь нь прокурорын байгууллагын прокурор, 27 хувь өмгөөлөгч, 22 хувь нь Авлига, тагнуул, цагдаагийн байгууллагын мөрдөгч, 21 хувь шүүгч, 2 хувь эрдэм шинжилгээний ажилтан, бусад албан хаагч эзэлсэн байна. Судалгаанд хамрагдсан оролцогчдын 88 хувь нь залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх ажиллагаанд оролцож байсан, ихэнх тохиолдолд хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгож, цахим хэрэгсэл ашиглаж, гэрээгээр халхавчилж залилах гэмт хэрэг үйлддэг байна.

Залилах гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад 53 хувь нь олон улсын гэрээ, конвенцыг судлах, гэмт хэргийн бодит хохирлыг нарийвчлан тооцох аргачлалыг бий болгох шаардлагатай байна.

Хүн, хуулийн этгээдийн эрх зүйн мэдлэг тутмыг байдал нь гэрээгээр халхавчилсан залилах гэмт хэргийг бий болгоход хүргэх нэг шалтгаан болж байна.

Залилах гэмт хэргийн хохирлын хэмжээг эрүүгийн хуульд нарийвчлан тогтоох шаардлагатай эсэхийг тодруулахад 90 хувь нь онц их хэмжээг нэмж оруулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Залилах гэмт хэрэг үйлдэгдэгчдийн арга нь улам бүр нарийсаж Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндсэн шинжүүдээр хязгаарлагдахгүй, тохиолдолд хууль бус аргаар үйлдэгдэж байх тул шийдвэрлэхэд хүндрэлтэй нь судалгааны явцад тогтоогдсон байна.

---o0o---